

ОТГОНТЭНГЭР ИХ СУРГУУЛИЙН ЦАХИМ СУРГАЛТАД БАРИМТЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль, ОТИС-ийн дотоод дүрэм, журмын хүрээнд цахим сургалт эрхлэх, түүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2 Цахим сургалтын үндсэн зорилго нь ОТИС-ийн сургалтын хөтөлбөрт тусгасан хичээлээс сонгон суралцахаар төлөвлөсөн суралцагчдад цаг хугацаа, орон зайгаас үл хамааруулан боловсролын үйлчилгээг хүргэх боломж бүрдүүлэхэд оршино.

1.3 ОТИС-аас санал болгох зэргийн бус сургалтыг цахим хэлбэрээр явуулах үйл ажиллагааг тусдаа журмаар зохицуулна.

1.4 Цахим сургалтын төлбөр нь танхимын сургалтын багц цагийн төлбөртэй ижил байна.

1.5 Цахим сургалтыг зохион байгуулахтай холбоотойгоор энэхүү журмаар зохицуулахгүй асуудлыг ОТИС-ийн сургалтын журмаар зохицуулна.

1.6 Цахим сургалт явуулах үйл ажиллагаа нь хичээлийн агуулгыг цахим хэлбэрт шилжүүлэх болон сургалтын үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах гэсэн үндсэн холр үе шаттай байна.

Хоёр. Журмын нэр томьёо

2.1. Хичээлийн багц материал (Course content): Сургалт явуулахад багшийн бэлтгэх шаардлагатай бүр төрлийн хэрэглэгдэхүүнийг хэлнэ. Үүнд дараах төрөл, түүний хэлбэрийг хамааруулна.

№	Төрөл	Хэлбэр
1	Хичээлийн хөтөлбөр	Хичээлийн батлагдсан хөтөлбөр, хөтөлбөрийн гарын авлага
2	Хичээлийн товч танилцуулга	Тухайн зааж байгаа улирал, ангид зориулан гаргасан товч танилцуулга, видео танилцуулга
3	Лекцийн хичээлийн видео	Хичээлийн агуулгыг тайлбарласан MP4 өргөтгөлтэй видео материал
4	Үзүүлэн	PPT, JPG болон бусад
5	Семинарын удирдамж	Ажлын материал
6	Бие даалтын удирдамж	Ажлын материал, гарын авлага
7	Шалгалтын сан	Улирлын, явцын, тест болон бодлогын, кейс г.м
8	Бие даан суралцах материал	Хичээлтэй холбогдуулан суралцагчдын уншиж судлах шаардлагатай үндсэн болон нэмэлт сурах бичиг, материал, цахим эх сурвалж

2.2. Цахим хичээл (Online course): Хичээлийн багц материалыг суралцагчдад цаг хугацаа, орон зайгаас үл хамааран, мэдээллийн технологийг ашиглан бие даан судлах боломжтой болгон боловсруулж бэлтгэсэн хичээлийг;

2.3. Цахим хичээл нь бүрэн цахим болон холимог хичээл гэсэн хэлбэртэй байж болно.

2.4. Бүрэн цахим хичээл (Full online course): Хичээлийн багц материалын бүх төрөл, хэлбэрийг цахим байдлаар бэлтгэсэн хичээлийг ойлгоно.

2.5. Холимог хичээл (Blended online course): Хичээлийн багц лекцээс бусад хэлбэрийг цахим хэлбэрт шилжүүлээгүй буюу танхимд судлахаар бэлтгэсэн хичээлийг;

2.6. Сургалтын үйл ажиллагаанд үүсэх харилцаа (Communication): Сургалтын явцад багш болон суралцагчдын хооронд үүсэх харилцааг; үүнд дараах төрөл хэлбэрийг ойлгоно.

№	Төрөл	Хэлбэр
1	Хичээлийн агуулгыг хүргэх	Лекц, семинарын хичээл явуулах
2	Зөвлөгөө өгөх	Оюутанд зөвлөгөө өгөх, хэлэлцүүлэг хийх
3	Үнэлэх	Явцын болон улирлын шалгалт, даалгавар, бие даалт, ангийн ажил, тайланг шалгаж дүгнэх

2.7. Цахим сургалт (Online learning): Мэдээлэл холбооны технологид суурилан мэдлэг, ур чадвар олгоход чиглэсэн сургалтын үйл ажиллагааг; Энэ нь цахим сургалтын орчинд явагдаж, суралцагчдад хичээлээ давтан болон нөхөн үзэх боломж олгоно. Цахим сургалт нь бүрэн болон холимог цахим сургалтын хэлбэртэй байж болно.

2.8. Бүрэн цахим сургалт (Full online learning): Сургалтаар үүсэх харилцааг бүрэн цахимаар явуулах сургалтын үйл ажиллагааг;

2.9. Холимог цахим сургалт (Blended online learning): Сургалтаар үүсэх харилцааны аль нэг төрөл хэлбэрийг танхимд явуулах шаардлагатай сургалтын үйл ажиллагааг;

2.10. Тонгоруу сургалт (Flipped classroom): Хичээлийн лекцийг цахимаар хүргэж, түүнийг бататгах семинар болон лабораторийн хичээлийг танхимаар явуулах холимог цахим сургалтын нэг хэлбэрийг;

2.11. Цахим сургалтын удирдамж (Instructional design): Тухайн цахим хичээлийн онцлог, хэлбэрээс хамааруулан сургалтын үйл ажиллагааны явцад үүсэх бүх төрлийн харилцааг хэрхэн зохион байгуулах талаар дэлгэрэнгүй тусгасан зааварчилгааг;

2.12. Агуулгын болон технологийн шаардлага (Content and technology requirements): Тухайн хичээлийн хөтөлбөрт туссан агуулгыг бүрэн хамрах, цахим хичээлийн техник шаардлагыг хангасан эсэх шаардлагыг;

Гурав. Цахим хичээлийн удирдлага, зохион байгуулалт

3.1. Цахим хичээлийг улирал бүр тэнхимийн саналд үндэслэн явуулна.

3.2. Нэг хичээлийг нэг улиралд танхимын болон цахим хэлбэрээр зэрэг явуулж болно.

3.3. Цахим сургалтыг ОТИС-ийн цахим сургалтын платформоор зохион байгуулна.

3.4. Цахим сургалтын хичээл бүрдүүлэлт, сонголт, үнэлгээ зэрэг нь ОТИС-ийн сургалтын үйл ажиллагааны журмаар зохицуулагдана.

3.5. Бүтцийн сургууль, тэнхимийн удирдлага цахим сургалтыг удирдлагаар хангаж зохион байгуулна.

3.6. Цахим сургалтын үйл ажиллагаанд бүтцийн сургууль, тэнхим хяналт тавьж ажиллах ба цахим сургалтын тайланг жил бүр гаргаж ЗХШҮА-д хүргүүлэх ба ЗХШҮА нь цахим сургалтын чанарт үнэлгээ хийж тайлагнана.

3.7. Сургалтын нэгдсэн алба дараах чиг үүрэгтэй:

3.7.1. Цахим сургалтын үйл ажиллагааг хөтөлбөрийн хороо, ректорын зөвлөлөөс гаргасан шийдвэр, чиглэлийн дагуу зохион байгуулах;

3.7.2. Цахим сургалтын хуваарь, цахим контент боловсруулах студийн хуваарь, холимог сургалтын үед ашиглах лабораторийн хуваарь гарган багш нарыг өдөр тутмын удирдлагаар хангах;

3.7.3. Суралцагчдын хамрагдах хичээлийн хуваарийг хүргэж, хичээлд оролцох бэлтгэлийг хангах, ирц, дүнг нягтлан, нэгтгэх;

3.7.4. Олон нийтэд цахим сургалтын талаар үнэн зөв мэдээлэл түгээх;

3.7.5. Цахим сургалтын явцад хяналт тавих зорилгоор сургалтын нэгдсэн албаны дарга, менежерүүд нь цахим ангиудад бүртгэлтэй байна.

3.8. Бүтцийн сургуулийн захирал дараах чиг үүрэгтэй ажиллана:

3.8.1. Цахим сургалтын хөтөлбөр, чанарыг сайжруулахад чиглэсэн сургалт, хэлэлцүүлэг хөтөлбөрийн дэд хороодтой хамтран зохион байгуулж, сургалтын чанарыг тогтмол сайжруулах ажлыг удирдан зохион байгуулах.

3.8.2. Багш нарын бэлтгэсэн цахим хичээлийн видео бичлэгийн агуулга, чанарт үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж өгөх;

3.8.3. Багшийн хөгжлийн төвтэй хамтран багш нарт шаардлагатай сургалтыг захиалах, зохион байгуулах

3.9. Тэнхим дараах чиг үүрэгтэй:

3.9.1.Цахим хичээлийн багц, хичээлийн төлөвлөлтийг багш нараар хангуулж, урьдчилан танилцаж, батлах

3.9.2.Цахим хичээлийн агуулгын шаардлага хангасан байдалд үнэлгээ өгч, сайжруулахад чиглүүлэн ажиллах

3.9.3.Цахим хичээлийн сан үүсгэж, хаягжуулах, цахим хэлбэрээр хадгалах ажлыг зохион байгуулах.

3.9.4.Сургалтын нэгдсэн алба, ангийн зөвлөх багш нар, оюутан, тэдний эцэг эхийг нягт холбон ажиллах, мэдээллээр хангах, шаардлага тавих

3.10. Цахим сургалтын үйл ажиллагаанд багш дараах чиг үүрэгтэй ажиллана:

3.10.1. Багш цахим хичээлийн агуулгыг сургалтын төлөвлөгөөний дагуу чанартай бэлтгэнэ.

3.10.2. Багшийн урьдчилан бэлтгэсэн хичээл дараах шаардлагыг хангасан байна:

- Үг зүй, найруулгын алдаагүй байх
- Видео хичээлийн агуулга оновчтой, дуу дүрс тод, ярианы түвшин хэт нам, хэт чанга биш, энгийн ойлгомжтой байх
- Дүрс бичлэг нь орчны дуу чимээ багатай бичигдсэн байх
- Нэг сэдвийн агуулга нь тус тусдаа нэг ойлголтыг агуулсан хэд хэдэн дүрс бичлэгээс тогтож болох ба нэгж хичээлийн бичлэгийн урт нь 15 минутаас хэтрэхгүй байх.
- Лекцийн сэдэв бүрд бие даан дэлгэрүүлж судлах материалын мэдээллийг оруулах ба семинарын сэдэв бүрийн ард даалгавар оруулсан байна.

3.10.3. Багш тухайн хичээлд оролцсон оюутны ирцийг сэдвийн төгсгөлд өгсөн асуултад хариулсан байдлаар эсхүл тухайн цагт оролцсон оролцооны аль нэгээр бүртгэх ба ямар байдлаар бүртгэхийг тухайн багш шийдвэрлэнэ.

3.10.4. Танхимаар орох 90 минутын хичээлийг шууд цахимаар ороход 90 минутаас бага байхаар багш зохицуулалт хийж болох бөгөөд энэ тохиолдолд тухайн сэдвийн агуулгыг төлөвлөгөөний дагуу бүрэн өгсөн байна.

3.10.5. Багш хичээлээ нэгдсэн платформыг ашиглан заах бөгөөд OneMis системд үүссэн ангид хичээлийн агуулга, цахим журналыг бүрэн оруулж, ирцийн бүртгэл, дүнгийн бүртгэлийг тухай бүр нь хөтөлнө.

3.10.6. Багш Microsoft teams-ээр дамжуулан оюутантай харилцахыг аль болох эрмэлзэх ба ажлын цагаар teams чатаар оюутны асуусан асуултад хариулт өгч ажиллана.

3.11. Цахим сургалтын үйл ажиллагаанд багш дараах эрхтэй:

3.11.1. Цахим сургалтыг явуулах нөхцөл боломжоор хангуулах;

3.11.2. Цахим номын санд байршсан ном, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, нээлттэй эх сурвалж, сургалтын материалыг хэрэглэх;

3.11.3. Суралцагчдаас ирүүлсэн санал хүсэлтийг сургуулийн удирдлагад тавьж шийдвэрлүүлэх

3.11.4. Цахим сургалтын талаар мэрээ, мэдээлэл авах;

3.11.5. Үндсэн хичээлийн материалыг сургалтын хөтөлбөрийн дагуу цахим сургалтын хэлбэрт шилжүүлэх, хүргэх, цахим хичээлийг удирдах, оюутан сургалтын мэдээллийг тайлагнах, суралцагчийн санал шүүмжлэлийг хүлээн авах, цахим хичээлийн агуулгыг сайжруулах, сан үүсгэх;

3.11.6. Улирлын шалгалтын материал бэлтгэн, тэнхимийн эрхлэгч, сургалтын нэгдсэн албаар хянуулан, батлуулах;

3.11.7. Лаборатори, дадлагын хичээлийг виртуал болон бусад хэлбэрээр (видео, симуляци) оюутан суралцагчид хүргэх;

3.11.8. Хүндэтгэх шалтгаанаар хичээл орох боломжгүй үед сургалтын нэгдсэн албанд урьдчилан мэдэгдэх;

3.11.9. Хичээлийг танхимаар болон цахим хэлбэрээр, эсхүл хослуулан /холимог болон тонгоруу/ цахим сургалт зохион байгуулах боломж, хэрэгцээ шаардлагын талаарх санал, хүсэлтийг сургалтын нэгдсэн албанд уламжилж, шийдвэрлүүлэх

3.12. Суралцагч дараах эрх, үүрэгтэй:

3.12.1. Цахим сургалтын талаар заавар, зөвлөгөө болон сургалтын хөтөлбөр агуулгад нийцсэн, чанартай сургалтын үйлчилгээг цахимаар авах;

3.12.2. Цахим сургалтын талаар мэдээ, мэдээллийг хичээл зааж буй багш, ангийн зөвлөх багш, сургалтын нэгдсэн албанаас авах;

3.12.3. Цахим сургалттай холбоотой санал, хүсэлт гаргах;

3.12.4. Хүндэтгэх шалтгаанаар хичээлдээ оролцох боломжгүй үед сургалтын нэгдсэн албанд болон багшид урьдчилан мэдэгдэх;

3.13. Оюутан дараах үүрэгтэй:

3.13.1. Өөрийн гар утас, компьютер болон хичээл судлах боломжтой бусад техникт "Microsoft teams" программыг татаж суулгасан, цахим хичээлийн бэлтгэлийг хангасан байна.

3.13.2. Оюутнууд өөрийн оюутныкод@otu.edu.mn домэйн хаяг бүхий цахим хаягаар teams программд нэвтэрч, өөрийн судлах хичээлийн групп тус бүрд нэгдсэн байна.

3.13.3. Хичээлд хуваарийн дагуу бүрэн хамрагдаж, идэвхтэй оролцон, бие даалт, даалгаврыг цаг тухайд нь хийж гүйцэтгэнэ.

3.13.4. Цахимд байршуулсан хичээлийг бие даан судалж, бататгал хичээлийн үеэр ойлгоогүй зүйлээ асууж, тодруулна. Өөрийн бие даан суралцах чадварыг хөгжүүлж, хичээлийн хуваарийн дагуу танхимын хичээлийн нэгэн адил цаг зарцуулж суралцана.

3.13.5. Өөрийн судалж буй хичээлийн агуулгыг бүрэн эзэмшихийн тулд идэвх, санаачилгатай байж, нэмэлт судлах материалыг заавал судалж, хичээлд идэвхтэй оролцоно.

3.13.6. Сургалттай холбоотой асуудлаар багштай холбогдоход ажлын цагаар teams чат хэсгийг ашиглана.

3.13.7. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хичээлд хамрагдах боломжгүй болсон бол энэ тухайгаа хичээл заах багш болон ангийн зөвлөх багшид мэдээлж, чөлөөг албан ёсоор авсан байна.

Дөрөв. Танилцах, мэргэших, үйлдвэрлэлийн болон багшлах дадлагын зохион байгуулалт

4.1. Танилцах, мэргэших, үйлдвэрлэлийн болон багшлах дадлагуудыг холбогдох тэнхим, сургууль цахимаар зохион байгуулж, хамгаалуулах зохицуулалтыг хийнэ.

4.2. Сургалтын үйл ажиллагаанд саад болохгүй хийх боломжтой дадлагыг салбар тэнхимээс гарсан санал, удирдамжийг үндэслэн орон нутагт ганцаарчлан хийлгэж болно.

4.3. Оюутан дадлагыг өндөржүүлсэн бэлэн байдлын дараа биечлэн хийх хүсэлт гаргавал хүсэлтийн дагуу шийдвэрлэн төгсөх хугацааг хойшлуулж болно.

4.4. Дадлагын тайлан хамгаалалтыг цахимаар зохион байгуулж болох бөгөөд цахимаар тайлан хамгаалах удирдамжийг тухайн сургуулийн захирал боловсруулж, Сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн проректороор батлуулан багш, оюутнуудад танилцуулсан байна.

Тав. Багшийн ажлын гүйцэтгэлийг тооцох

5.1. Цахим сургалтын хугацаанд багш нэгж хичээл бүрд дараах шаардлагыг хангаснаар сургалтын А цагийн кредитийн гүйцэтгэлийг тооцуулна.

5.2. Цахим хичээл тус бүр цахим хичээлийн багцыг бүрэн бүрдүүлсэн байх

5.3. Цахим хичээл агуулгын болон техникийн шаардлага хангасан байх

5.4. Цахим хичээлийг хуваарийн дагуу цахим платформд оруулсан байх

5.5. Оюутантай семинар хичээл зэргээр дамжуулан эргэх холбоотой ажиллаж байгааг баримтжуулан, явцын даалгавар, үнэлгээндээ анализ хийсэн байх

5.6. Багш цахим сургалтын дараа сургалтын тайлан бичиж, өөрийн үнэлгээ хийсэн байх

5.7. Цахим хичээлийн багцыг тэнхимд хүргүүлж, цахим хэлбэрээр хадгалуулсан байх

Зургаа. Бусад

6.1. Цахим сургалтын хичээлийн хөтөлбөр сургуулийн өмч байна. Цахим хичээлийн багцын зохиогчийн эрхийг сургууль гэрээний үндсэн дээр шилжүүлэн авч болно. Цахим сургалтын чанарыг сайжруулах чиглэлээр хариуцсан тэнхим, нэгжүүд шаардлагатай асуудлыг цаг тухайд нь сургалтын нэгдсэн албанд мэдэгдэж, ректорын зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ. Цахим сургалттай холбоотой санал, гомдлыг sna@otgontenger.edu.mn хаягаар болон ОТИС-ийн ЗХШҮА-д бичгээр хүлээн авна.